

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2014.11.14

Чойр

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2014 онд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд аймгийн авлигын эсрэг төлөвлөгөөг Тахил тогоот төрийн бус байгууллагын оролцоотойгоор иргэд, байгууллагын санал хүсэлтийг тусган боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 03 сарын 03-ний өдрийн А/11 тоот тушаалаар батлан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Мөн авлигатай тэмцэх төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ажиллаж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах ажилтантай болох, тухайн ажилтаны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн А.Мягмаржамцыг 2014 оны 04 сарын 01-ний өдрөөс аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар авлигатай тэмцэх асуудал хариуцсан Эрх бүхий албан тушаалтанаар томилон ажиллуулж байна.

Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд:

Аймгийн болон байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангахын тулд цахим хуудас болон мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчлан ажиллаж байна.

Аймгийн албан ёсны вэб хуудас болох <http://www.govisumber.gov.mn> хаягт байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор төрийн байгууллагуудын зүгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, аймгийн хэмжээний бодлогын баримт бичгүүд түүний хэрэгжилтийн тайлан, аймгийн засаг даргын захирамжууд, аймгийн төсвийн ил тод байдлын талаарх мэдээлэл, хүний нөөц, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллүүд, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал, аймгийн Засаг даргын Тамгын газрын сарын ажлын тайлан, иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, тендерийн зар, төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар, аймагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаарх мэдээллүүдийг тухай бүр байршуулан, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны үр дүнд нь цогц байдлаар үнэлгээ өгөх зорилгоор төрийн байгууллагууд болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2014 онд хийхээр төлөвлөсөн авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлэх тухай албан тоотыг доорхи 28-н байгууллагуудад хүргүүлсэн.

Үүнд:

№	Байгууллагын нэр	Хэзээ ирүүлсэн он, сар, өдөр	Тайлбар
1	Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар	2014.02.28	Ирүүлсэн
2	Мэргэжлийн хяналтын газар	2014.03.02	Ирүүлсэн
3	Цагдаагийн хэлтэс	2014.03.03	Ирүүлсэн
4	Статистикийн хэлтэс	2014.04.01	Ирүүлсэн
5	Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар	2014.04.16	Ирүүлсэн
6	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс	2014.04.16	Ирүүлсэн
7	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	2014.04.17	Ирүүлсэн
8	Тээвэр авто замын газар	2014.04.18	Ирүүлсэн
9	Шивээговь сумын ерөнхий боловсролын 3-р сургууль	2014.04.18	Ирүүлсэн
10	Худалдан авах ажиллагааны алба	2014.04.18	Ирүүлсэн
11	Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн газар	2014.04.18	Ирүүлсэн
12	Илчлэг-шивээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	2014.04.21	Ирүүлсэн
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс	2014.04.21	Ирүүлсэн
14	Татварын хэлтэс	2014.04.21	Ирүүлсэн
15	Соёл, спорт, аялал жуулчлалын газар	2014.04.21	Ирүүлсэн
16	Боржигон чуулга	2014.04.22	Ирүүлсэн
17	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар	2014.04.23	Ирүүлсэн
18	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	2014.04.24	Ирүүлсэн
19	Говьсүмбэр аймгийн боловсролын газар	2014.05.26	Ирүүлсэн
20	Байгаль орчны газар	2014.05.29	Ирүүлсэн
21	1-р сургууль	2014.05.23	Ирүүлсэн
22	2-р сургууль	2014.05.23	Ирүүлсэн
23	4-р сургууль	-	Ирүүлээгүй
24	5-р сургууль	2014.04.28	Ирүүлсэн
25	Нийгмийн даатгалын хэлтэс	2014.05.26	Ирүүлсэн
26	УС-ДУ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	-	Ирүүлээгүй
27	Талын илч	-	Ирүүлээгүй
28	Тохижилт сүмбэр	2014.04.30	Ирүүлсэн

Дээрх 28-н байгууллагаас УС-ДУ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Талын илч орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 4-р сургууль гэсэн 3-н байгууллага авлигын эсрэг төлөвлөгөө ирүүлээгүй байна. Бусад 25 байгууллага нь ирүүлсэн байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр:

Хууль зүйн хэлтсээс зохион байгуулдаг эрх зүйн сургалт сурталчилгааны албан ёсны хуваарийн дагуу төрийн байгууллагуудад авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар нийт 32 байгууллагын 380 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.

Сургалтыг хөтөлбөрийн дагуу байгууллага тус бүрт хийсэн.

Сургалтыг зохион байгуулах явцад авлига, ашиг сонирхлын чиглэлээр тухайн сургалтад хамрагдсан байгууллага, түүний ажилтан, алба хаагчдад санал асуулгын хуудас тарааж, санал асуулгын дүнг нэгтгэж гаргалаа.

Танай байгууллагын удирдлага 2014 онд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигтай тэмцэх асуудлаар ажилтнуудтайгаа харилцан яриа өрнүүлсэн үү ? гэсэн санал асуулгын хуудсыг нийтдээ 361 хүнээр бөглүүлж авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 24.64% буюу 89 нь манай байгууллагын удирдлага 2014 онд авлигаас урьдчилан сэргийлэх,


авлигатай тэмцэх асуудлаар ажилтнуудтайгаа харилцан яриа өрнүүлсэн гэсэн бол 41.23% буюу 149 нь нэг удаа, 34,12% буюу 123 нь аливаа байдлаар харилцан яриа өрнүүлээгүй гэсэн үр дүн гарсан байна.

График-1




Та удирдлагынхаа авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн үнэлдэг вэ ? гэсэн санал асуулгын хуудсыг нийтдээ 356 хүнээр бөглүүлж авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 61.65% буюу 220 нь сайн гэсэн бол 27.67% буюу 98 нь дунд зэрэг, 10,68% буюу 38 нь муу гэж үнэлжээ.

График-2




Танай удирдлага таны бодит байдалд нийцсэн, хууль зүйн дагуу бэлтгэсэн саналыг өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу ? гэсэн санал асуулгын хуудсыг нийтдээ 351 хүнээр бөглүүлж авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 77.61% буюу 273 нь тийм тохиолдол байхгүй гэсэн бол 14.42% буюу 51 нь хааяа өөрчилдөг, 7,96% буюу 27 нь сэжигтэй байдлаар өөрчилдөг гэж хариулжээ.

График-3



Танай байгууллагын удирдлага авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төсөв, санхүүг баталж өгдөг үү ? гэсэн санал асуулгын хуудсыг нийтдээ 333 хүнээр бөглүүлж авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 33.33% буюу 111 нь тухай бүр баталж өгдөг гэсэн бол 26.23% буюу 87 нь зарим ажлын төсвийг баталж өгдөг, 40,43% буюу 135 нь баталж өгдөггүй гэж хариулсан байна.



оролцогчдын 33.33% буюу 111 нь тухай бүр баталж өгдөг гэсэн бол 26.23% буюу 87 нь зарим ажлын төсвийг баталж өгдөг, 40,43% буюу 135 нь баталж өгдөггүй гэж хариулсан байна.

Танай байгууллагын удирдлагаас тухай жилд баталж, хэрэгжүүлсэн “ Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” түүний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнууддаа танилцуулсан уу ? гэсэн санал асуулгын хуудсыг нийтдээ 340 хүнээр бөглүүлж авсан бөгөөд нийт санал асуулгад оролцогчдын 48.94% буюу 166 нь тийм гэсэн бол 51.05% буюу 174 нь үгүй гэж хариулсан байна.



Дд	Асуулт	Хариулт		
		Байнга	Нэг удаа	Өрнүүлээгүй
1	Танай байгууллагын удирдлага 2014 онд авлигаас урьдчилан сэргийлэх, авлигтай тэмцэх асуудлаар ажилтнуудтайгаа харилцан яриа өрнүүлсэн үү ?	24.64%	41.23%	34.12%
2	Та удирдлагынхаа авлигтай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг хэрхэн үнэлдэг вэ ?	Сайн	Дунд	Муу
		61.65%	27.67%	10.68%
3	Танай удирдлага таны бодит байдалд нийцсэн, хууль зүйн дагуу бэлтгэсэн саналыг өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу ?	Байхгүй	Хааяа өөрчилдөг	Сэжигтэй байдлаар өөрчилдөг
		77.61%	14.42%	7.96%
4	Танай байгууллагын удирдлага авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төсөв, санхүүг баталж өгдөг үү ?	Тухай бүр баталж өгдөг	Зарим ажлын төсвийг баталж өгдөг	Баталж өгдөггүй
		33.33%	26.23%	40.43%
5	Танай байгууллагын удирдлагаас тухай жилд баталж, хэрэгжүүлсэн “ Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” түүний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнууддаа танилцуулсан уу ?	Тийм		Үгүй
		48.94%		51.05%

Мөн 2014 оны 04 сард Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтэс, Мерси кор олон улсын байгууллага, Тахил тогоот төрийн бус байгууллага хамтран авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар

Д.Мөнхжаргалыг урьж авчирч Сайн засаглалын төлөө хамтдаа хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 21 байгууллагын 45-н ажилтан албан хаагчид оролцсон байна.

Энэ үеэр Авлигын эсрэг хуульд орсон хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдээлэл өгсөн.

Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтээ нийт 18-н байгууллагаас аваад байна. Биелэлтэнд дүн шинжилгээ хийж, сайн туршлага, авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанар хүртээмж, мэдээллийн ил тод байдлын талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа зэрэгтэй танилцан байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өглөө.

Ийнхүү үнэлэлт дүгнэлт өгөх нь төрийн байгууллага, түүний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санал санаачилга, хүчин чармайлтыг дэмжих, төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх, төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үлгэр жишээ, тэргүүн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх үндсэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо төслийн хүрээнд:

“Хууль дүрэм бодит амьдралд-2” аяны ажлын хэсэг тодорхой ажлуудыг Мерси Кор ОУБ-тай хамтарч зохион байгуулсан. Үүнд:

1. Баянтал, Шивээговь сумдад “Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сургалт явуулж, сургалтын дараа үзсэн хичээлийн сэдвийн хүрээнд АХА тэмцээн зохион байгуулсан. Үүнд 2 сумын нийт 78 төрийн албан хаагч оролцлоо.
2. Мерси Кор төв оффисс, авлигатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан арга зүйн зөвлөгөө өгөх онлайн сургалтанд Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Г.Билгүүнбаяр, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Э.Мөнхзул, Тахил тогоот ТББ-ын гишүүн Э.Сайхнаа нар Говьсүмбэр аймгаас, тахил тогоот ТББ-ын тэргүүн Д.Ариунаа, гишүүн Ш.Шинэбаяр нар Улаанбаатар хотод биечлэн оролцлоо.
3. Аяны хүрээнд тендэрийн лавлагаа мэдээлэл, хуулийн зөвлөгөөг багтаасан брошурын эхийг ХААА-тай хамтран бэлтгэж 500-ш-ыг хэвлүүлэн иргэдэд тараасан. Үүний 150 ширхэгийг нь аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцсон бизнес эрхлэгчдэд тараасан.
4. “Хууль дүрэм бодит амьдралд-Илтод төрийн худалдан авах ажиллагаа” нэгдсэн аяны танилцуулгын баннерийг хэвлүүлэн сүмбэр сумын төв зам дагуу байршуулсан. Самбар нь 2 талдаа хэвлэгдсэн 2*4-ын хэмжээтэй хэвлэлтийн зардлыг Мерси Короос гаргаж, аймгийн засаг даргын тамгын газар, хууль зүйн хэлтэс хүн хүч, унаа машин гаргаж байрлуулж өгсөн.
5. Аяны хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаа болон орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлыг сурталчилах, зорилгоор “Иргэдтэй ажиллах-нээлттэй өдөрлөг”-ийг 2014 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт төрийн захиргаа, удирдлагынхэлтэс, хууль зүйн хэлтэс, нийгмийн хөгжлийн хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэс болон аймгийн Засаг даргын дэргэдэх харьяа агентлаг,

хэлтсийн нийт 20 байгууллагын 71 албан хаагч оролцсон.Өдөрлөгт оролцсон иргэдээс санал асуулга авч “**Хамгийн ил тод байгууллага**”-г шалгаруулсан.

1-р байр хөдөлмөрийн хэлтэс шалгарч “**Хамгийн ил тод байгууллага**” гэсэн цом өргөмжлөл, 2-р байр нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, 3-р байр Нийгмийн даатгалын хэлтэс тус тус шалгарч өргөмжлөлөөр шагнасан.

6. Аяны хүрээнд “**Сайн засаглалын талаар хүүхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх тэдний дуу хоолойг насанд хүрэгчдэд хүргэх, хүүхдийн авъяас чадварыг нь нээн хөгжүүлэх, өсвөр үеийг авлигыг үл тэвчих хандлагад төлөвшүүлэх зэрэг**” зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хүүхдүүдийн дунд “**Сайн засаглал-Миний амьдралд**” сэдэвт эссе бичлэгийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээний удирдамжийг “Тахил тогоот” ТББ-ын гар зургийн уралдаантай хамтран боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан явуулсан. Уралдаанд 3 сургуулийн 14 хүүхдийн бүтээл ирсэн. Ирсэн бүтээлүүдийг ажлын хэсгийн гишүүд болох аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтсийн дарга П.Наранхүү, иргэний танхимын ажилтан Оюунтуяа, тахил тогоот ТББ-ын тэргүүн Д.Ариунаа нартай хамтран дүгнэж байр эзлүүлээ.

1-р байранд Сүмбэр сумын 2-р сургууль 11б ангийн сурагч **Г.Ариунтөгс**

2-р байранд Сүмбэр сумын 2-р сургуулийн 11а ангийн сурагч **Д.Нансалмаа**

3-р байранд Шивээговь сумын 3-р сургуулийн 10б ангийн сурагч **Э.Золжаргал** нар эзэллээ.

Шагналыг “Хариуцлагатай төрийн төлөө хамтдаа” сэдэвт сургалт хэлэлцүүлгийн үеэр гардуулан өгсөн.

“**Хууль дүрэм бодит амьдралд-2**” аяны хаалтын ажиллагаа үр дүнгийн хэлэлцүүлгийг 2014 оны 4 дүгээр сар 24 нд Сүмбэр сумын засаг даргын тамгын газрын хурлын заланд явууллаа. Хаалтын үйл ажиллагаанд Мерси Кор олон улсын байгууллагын аймаг дахь төслийн зохицуулагч Б.Буяншиг аяны хүрээнд хийгдсэн ажлуудаа танилцуулж, боржигдай мэргэн, ХААХолбоо, төмөр замын ахмадынхолбоо, тахил тогоот ТББ-ууд тус бүр төслийн үйл ажиллагаа болон иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг хийж санал асуулга авсны үр дүнгээ нэгтгэн танилцуулж санал солилцлоо.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /ХАГАС ЖИЛЭЭР/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл	Биелэлт-ийн хувь
1.1	Аймгийн ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг /батлагдсан/ АТГ-т хүргүүлэх	-Төлөвлөгөө АТГ-т хүргэгдсэн байх -Нийтэд мэдээлэгдсэн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2014 оны авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 03 сарын 03-ний өдрийн А/11 дугаар тушаалаар баталж, авлигын эсрэг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний талаар зохих байгууллага, иргэдэд хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгээр дамжуулан мэдээлэл өгч ажилласан байна. Мөн авлигын эсрэг төлөвлөгөөг авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	100
1.2	Аймгийн засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн тайланг хагас жил тутам тайлагнах	-Хэрэгжилтийн түвшин тодорхойлогдсон байх	Аймгийн засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн тайланг 2014 оны хагас жилийн байдлаар гаргаж байгууллага,	100

			иргэдэд танилцуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байна.	
1.3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээний шаардлагатай зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх	-Шаардагдах хөрөнгө тодорхой болсон байх -Ирэх оны төсвийн төсөлд туссан байх	Авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтаны ажлын үр дүнгээр урамшуулах төсөвлөн тусгасан.	90
б/ Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах ажилтантай болох				
1.4.	Тухайн ажилтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцлийг хангах	-Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгагдсан байх -Байгууллагын онцлогт тохирсон байх -Сейф, лац, цахим сүлжээ, компьютер бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан байх -ЭБАТ-ны цалингийн зохих нэмэгдлийг олгож, тогтвортой ажиллуулсан байх	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн А.Мягмаржамцыг 2014 оны 04 сарын 01-ний өдрөөс аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар авлигатай тэмцэх асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтанаар томилон ажиллуулж байна. ЭБАТ ажилтаныг ажиллах нөхцөлийг хангах хүрээнд сейф, лац, компьютер тоног төхөөрөмж болон бусад хэрэгслээр ханган ажиллаж байна. ЭБАТ ажилтаныг түүний үндсэн цалингийн 30%-иар эрх бүхий албан тушаалтаны ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгож байна.	90
1.5.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг дүгнэн урамшуулах	-Эрх бүхий албан тушаалтаны үйл ажиллагаа дүгнэгдсэн байна	Аймгийн засаг даргын тамгын газрын эрх бүхий албан тушаалтаны үйл ажиллагааны үр дүнг хагас жилээр дүгнэсэн. Ажлын үр дүнг харгалзан бүтэн жилээр үйл ажиллагааг нь дүгнэж урамшуулахаар, урамшууллыг төсөвлөсөн.	90
в/ Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах				
1.6.	Аймгийн болон байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангахын тулд цахим хуудас болон мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	-Нийтэд хамрааралтай шийдвэр олон нийтэд мэдээлэгдсэн байх	Аймгийн болон байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангахын тулд цахим хуудас болон мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчлан ажиллаж байна. Аймгийн албан ёсны вэб хуудас болох http://www.govisumber.gov.mn хаягт байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор төрийн байгууллагуудын зүгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, аймгийн хэмжээний бодлогын баримт бичгүүд түүний хэрэгжилтийн тайлан, аймгийн засаг даргын захирамжууд, аймгийн төсвийн ил тод байдлын талаарх мэдээлэл, хүний нөөц, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллүүд, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал, аймгийн Засаг даргын Тамгын газрын сарын ажлын тайлан, иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, тендерийн зар, төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар, аймагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаарх мэдээллүүдийг тухай бүр байршуулан, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Мөн орон нутгийн Чойрын толь сониноор дамжуулан олон нийтэд хамааралтай мэдээлэл, шийдвэрийг хүргэж байна. Шинээр байгуулагдаж байгаа Шинэ-Чойр телевизтэй энэ талаар хамтран ажиллахаар удирдлагуудын түвшинд ярьж тохиролцоод байна.	100
г/ Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт				
1.8.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжин хамтран ажиллах	-Хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо сайжирсан байх	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2014 онд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд аймгийн авлигын эсрэг төлөвлөгөөг Тахил тогоот төрийн бус байгууллагын оролцоотойгоор иргэд, байгууллагын санал хүсэлтийг тусган боловсруулж,	90

			аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 03 сарын 03-ний өдрийн А/11 тоот тушаалаар батлан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	
1.9.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах ажилтнууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж амлалт өгч, шударга ёсыг тогтоох, авлига хүнд сурталгүй ажиллах талаар албан хаагчдад болон олон нийтэд мэдэгдэл хийх	-Тодорхой арга хэмжээ зохион байгуулагдсан байх -Ёс зүйн алдаа зөрчил гарсан байдал	Авлигыг үл тэвчигч, ёс зүйтэй хамт олон байх тухай аймгийн Засаг дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах ажилтнууд тамгын газрын нийт ажилтан албан хаагчдад болон олон нийтэд хандан мэдэгдэл гаргасан. Мэдэгдэлд Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын удирдах ажилтнууд бид "Сайн төр бол авлигагүй төр" гэсэн үзэл санааны дагуу "Авлигыг үл тэвчигч, ёс зүйтэй хамт олон байх"-ыг эрмэлзэн мэдэгдэж байна. Улс орны хөгжил, иргэдийн төрд итгэх итгэлийг алдагдуулж байгаа хүчин зүйлсийг эерэг болгоход өргөсөн тангарагтаа үнэнч, ёс зүйтэй, хуулийн хүрээнд шударга ёсыг эрхэмлэн ажиллах төрийн албан хаагч бидний идэвхи, оролцоо хамгаас чухал. Иймд бид бүхний эрмэлзэж байгаа "АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИГЧ, ЁС ЗҮЙТЭЙ ХАМТ ОЛОН БАЙХ" -ыг дэмжиж, өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг нийт иргэд болон авлигын эсрэг тэмцэхийг хичээн чармайж байгаа та бүхэнд Говьсүмбэр аймгийн Засаг дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газрын хамт олны өмнөөс мэдэгдэж байна гэжээ.	100
д/ Засаг даргын Тамгын газрын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн зүгээс саналаа илэрхийлэх				
1.10	Засаг даргын Тамгын газрын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх санал асуулгыг хэлэлцүүлэг хэлбэрээр явуулах	-Санал асуулгыг явуулсан байх -Нийтийг хамарсан байх -Энэ талаарх мэдээллийг цахим хуудастаа байршуулах -Нотлох баримтыг цуглуулах	Орон нутгийн хөгжил сангийн сангийн хөрөнгийг хэрхэн зарцуулах тал дээр иргэдээс санал байнга авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Авлигын эсрэг төлөвлөгөөний төсөлд иргэд, төрийн бус байгууллагаас санал аван боловсруулсан.	100
1.11	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах - мэдээллийн самбар - хэвлэмэл материал - цахим хуудас - мессеж мэдээлэл	-Нийтэд мэдээлсэн байх	Хууль зүйн хэлтсээс зохион байгуулдаг эрх зүйн сургалт сурталчилгааны албан ёсны хуваарийн дагуу төрийн байгууллагуудад авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар нийт 32 байгууллагын 380 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. Сургалтыг хөтөлбөрийн дагуу байгууллага тус бүрт хийсэн. Сургалтыг зохион байгуулах явцад авлига, ашиг сонирхлын чиглэлээр тухайн сургалтад хамрагдсан байгууллага, түүний ажилтан, алба хаагчдад санал асуулгын хуудас тарааж, санал асуулгын дүнг нэгтгэж гаргасан. Авлигын эсрэг хууль тогтоомж сурталчилсан гарын авлага, брошур бэлдэж өдөрлөгүүд дээр иргэд, байгууллагад тараан ажиллаж байна.	90
1.12	Иргэд, байгууллагад олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, олгох журмыг ил тод нээлттэй байлгах	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах	Иргэд байгууллагад олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай бичиг баримтын жагсаалт, олгох журмыг аймгийн телевизээр 3 удаа, мөн аймгийн вэб сайт, хэлтсийн фэйсбүүк хуудсуудад тогтмол тавьж ажиллаж байна. Тухайлбал архи, тамхины худалдааны зөвшөөрөл, сургууль эмнэлэг, эмийн сан байгуулах зөвшөөрөл гэх мэт.	90
1.13	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дууссан хугацааг цахим хуудсанд байршуулах	Нийтэд мэдээлсэн байна Цахим хуудаст байршуулах	Иргэд, байгууллагад олгож буй зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хугацааг мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна.	90

ХОЁР. ШУДАРГА БАЙДАЛ				
а/ Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох				
2.1.	Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт, хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй байлгах	-Албан хаагч бүрийн ажил үүргийн талаарх хуваарь олон нийтэд ил байрласан байх -Тухайн албан тушаалтныг олоход хялбар болох	Аймгийн засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт тус бүрийг шинэчлэн ажил үүргийн шинэ хуваарь гаргаж энэ талаарх мэдээллийг ил тод байдлын самбарт байрлуулан ажиллаж байна.	90
2.2.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцож, зөрчлийн талаарх бүртгэл, хөтлөлтийг зохион байгуулна.	-Тогтмол утас, цахим шуудан ажиллуулсан байна -Нийтэд мэдээлсэн байна -Хариуцлага тооцсон байна -Бүртгэл хөтөлсөн байна	Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг 70543434 дугаарийн нээлттэй утас болон санал хүсэлтийн хайрцагаар авах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	90
2.3.	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж хариуцлага тооцох	-Хуульд нийцсэн байна -Дүгнэлт гаргасан байна	Одоогоор төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл 3 бүртгэгдсэн байна.	100
б/ Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг мэдэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх				
2.4.	Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг сурталчилж хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх, мэдээ, тайланг Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	-Ёс зүйн зөрчлийн мэдээг гаргаж олон нийтэд мэдээлсэн байна -Ёс зүйн зөрчлийн мэдээг Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газарт хагас жил тутам хүргүүлсэн байна	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх мэдээг аймгийн цахим хуудсанд байршуулан ёс зүйн зөрчлийн талаарх мэдээг төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.	100
2.5.	Ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдол, давуу талуудын талаар мэдлэгтэй болгох	-Сургалтанд бүрэн хамрагдсан байх -Сургалт давтамжтай байх -Сургалт үр дүнгээ өгсөн байх	Ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдол, давуу талуудын талаарх сургалтыг аймгийн засаг даргын Тамгын газрын ажилтнуудад эхний хагас жилийн байдлаар 4 удаа явуулаад байна.	90
2.6.	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах	-Урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлж дүгнэлт ирсний дараа томилгоог хийж хэвших -ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан тайланг АТГ-т хүргүүлсэн байх	Ажилтан албан хаагчдын 2013 хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг энэ оны 2 дугаар сарын 15-нд авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн шинээр орж буй ажилтан албан хаагчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь цахимд бүртгэх ажлыг тухай бүр хийж байна.	100
ГУРАВ. ИЛ ТОД БАЙДАЛ				
а/ Хүний нөөцийн ил тод байдлыг хангах				
3.1.	Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, журмыг олон нийтэд нээлттэй байлгах	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах	Төрийн албаны сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөцийн бодлого, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээллийг байршуулан шинэчлэн ажиллаж байна.	100
3.2.	Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах		
3.3.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх гүйцэтгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах		
б/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах				
3.4.	Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	Холбогдох байгууллагад хандсан байна. -Нийтэд мэдээлсэн байна.	Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, аймгийн вэб сайт болон www.e-procurement.mn вэб сайтад байршуулан ажиллаж байна. 2015 оны төлөвлөгөө гарах хугацаа болоогүй байна. Мөн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдийн талаарх мэдээллийг www.e-procurement.mn сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна. Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайланг гаргаж хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Одоогоор тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчил дутагдлын тохиолдол гараагүй	90
3.5.	Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вебсайтад байршуулах			
3.6.	Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл			
3.7.	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан			
3.8.	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх			
3.9.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн			

			ба оролцогчдоос гарсан 2 гомдол сангийн яаманд хянагдаж захиалагчийн талд шийдвэр гарсан болно.	
г/ Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг веб сайтад байршуулах				
3.12	Тухайн жилийн төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 5 дугаар сарын 5-ны дотор, дараа жилийн төсвийн төслийг 8 дугаар сарын 25-ны дотор -Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 5-ны дотор -Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 6 дугаар сарын 1-ний дотор тус тус цахим хуудсанд байршуулж мэдээлнэ.	-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан шаардлагын дагуу мэдээлэх, вебсайтад байршуулах	2014 оны төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 5 дугаар сарын 5-ны дотор -Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 5-ны дотор -Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 6 дугаар сарын 1-ний дотор тус тус цахим хуудсанд байршуулсан. Мөн 2015 оны төсвийн төслийг 08 дугаар сарын 25-ний дотор байршуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.	100
3.13	2014 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл	-Ороогүй бол энэ тухай мэдээлэх	2014 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг аймгийн вэб сайтад байршуулсан байна.	90
3.14	Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаарх 2013 оны мэдээлэл хийх /татварын, татварын бус/	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан шаардлагын дагуу мэдээлэх, веб сайтад байршуулах	2014 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр байхгүй бөгөөд Аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн талаарх 2013 оны мэдээлэл аймгийн вэб сайтад тавигдсан. Мөн 2014 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий хүмүүсийн нэрсийн жагсаалтыг аймгийн вэб сайтад байршуулсан.	90
3.15	Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний талаарх мэдээллийг сайжруулах			
3.16	2014 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг веб сайтад байршуулах			
3.17	2014 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр жагсаалтыг гаргаж АТГ-т хургүүлэх			
3.18	Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг веб сайтад байршуулах			
д/ Иргэдийн өргөдөл, санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх				
3.19	Иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах нээлттэй утас ажиллуулж, түүний сайн туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэх	-Иргэдийн төрд хандах хандлага эерэг болж өөрчлөгдөнө. -Хэрхэн шийдвэрлэсэн талаарх хариу өгч хэвшсэн байдлаар	Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах нээлттэй утсыг ажиллуулж байна. Утсаар ирж буй өргөдөл, гомдол, санал хүсэлтийг тусгайлан бүртгэдэг бөгөөд хариуг хуулийн хугацаанд утсаар болон бичгээр хариу мэдэгдэж энэ тухайгаа тэмдэглэл үйлдэж шийдвэрлэсэн албан тушаалтаны гарын үсгийг зуруулж хэвшээд байна. Ингэснээр иргэд нээлттэй утсанд ам сайтай байна.	100
ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ				
а/ Авлигын эрсдэл, авлига гарах боломжийг бууруулах				
4.1.	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах /уг арга хэмжээнд олон нийтийг татан оролцуулах, тодорхой судалгаа шинжилгээний үндсэн дээр тулгуурлах/	-Авлигатай тэмцэх газартай санал солилцсон байх -Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргасан байх	Хууль зүйн хэлтсээс авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын жагсаалтыг 2014 оны 2-р улиралд гаргасан байгаа.	100
4.2.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах	-	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр авлигад өртөх эрсдэлтэй байгууллагуудын удирдлагуудад 4 удаагийн сургалт зохион байгуулаад байна.	100
б/ Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар авлигатай тэмцэх газарт мэдээлэх				
4.3.	Албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигын зөрчлийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх, хянан шалгаж буй материалыг харьяаллын дагуу шилжүүлэх	Авлигатай тэмцэх газарт мэдээллийг шилжүүлсэн байна	Хяналт, шинжилгээ үнэлгээний батлагдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн мэргэжилтэнүүд холбогдох байгууллагуудад тодорхой хөтөлбөрийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээгээр ажиллахад авлигын шинж чанартай ямар нэгэн зөрчил илрээгүй байна.	100
в/ Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчдөд харуцлага тооцох				

4.4.	Холбогдох эрх бүхий байгууллагаас зөрчлийг хянан тогтоож ирүүлсэн мэдэгдэл, хариуцлага тооцуулах саналын дагуу хуулийн хүрээнд арга хэмжээг авах	-Хариуцлага тооцсон байх	Авлигатай тэмцэх газраас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаагүй, эсвэл хоцроосон албан тушаалтанд хариуцлага тооцох тухай зөвлөмжийн дагуу тухай бүр албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж байна. Тухайлбал: Сүмбэр сумын засаг даргын орлогч, мэргэжилтэн нарт авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох хариуцлага, арга хэмжээг авсан.	90
4.5.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль зөрчсөн этгээд Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 04 сарын 24-ний өдрийн 74 дүгээр тушаалын хавсралтын дагуу сахилгын шийтгэлийн талаарх мэдээллээ холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээ хэвшүүлэх	-Мэдээлэл холбогдох этгээдэд хүргэгдсэн байх -Олон нийтэд мэдээлсэн байх	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зүйл заалт, агуулгыг зөрчсөн албан тушаалтанд авлигатай тэмцэх газрын даргын тушаалын дагуу арга хэмжээг авч энэ талаарх мэдээллээ холбогдох байгууллага нийтэд хүргэх арга хэмжээг авч хэвшээд байна.	90

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /ЖИЛЭЭР/**

Д/д	Арга хэмжээ ний тоо	Үүнээс							Хугацаа болоогүй	Тасарсан		Биелэлтийн дүн хувь
		Биелсэн 100%	Хэрэгжих шатандаа /%/							Зохион байгуулалтаас	Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас	
			90%	70%	50%	30%	10%	0%				
Бүгд	29	14	15	0	0	-	-	-	-	-	94.8%	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

А.МЯГМАРЖАМЦ

ХЯНАСАН:

П.НАРАНХҮҮ